



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/539

Номгон

“Эн Ар Жи Эс” ХХК-ний эзэмшил газрын  
байршлыг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эн Ар Жи Эс” ХХК-ний (5408512) хүсэлтийг харгалзан Баянхонгор сум, Угалз 4-р баг, Гурван бүсийн өргөн чөлөө-4, 401 тоот хаягт хаягт байрлах 6409008265 нэгж талбарын дугаар бүхий 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 53825 м2 газрын зүүн талын 3798 м2 газар нь автомашины замын зурвас газартай давхацсан тул тус газрын байршлыг шилжүүлсүгэй.

2.Шилжиж буй газрын байршлын мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Эзэмшил газрын байршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан газрыг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж, гэрээнд заасан үүргээ биелүүлэн жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч “Эн Ар Жи Эс” ХХК (Р.Баасанбавуу)-д тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

2023 оны 10 сарын 10 өдөр 64231139